

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 09 ДҮГЭЭР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**


2024 оны 10 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 09 дүгээр сарын биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын 33 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Нийт арга хэмжээний 75.76 хувь нь үр дүнтэй буюу 100 хувь, 18.18 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувьтай, 6.06 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-50 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна. (График 1, Хүснэгт 1)

График 1



Хүснэгт 1

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Хувь
	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	Дундаж хувь
	100%	90%	70%	50%	30%	0%	
1	2	3	4	5	6	7	8
33	25	5	1	1	1	-	93.94

Зорилт тус бүрээр ангилан авч үзвэл Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна” зорилтод тусгагдсан арга хэмжээ 90 хувь, Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна”-д 7 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлсэн нь 94.2 хувь, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” зорилтод

хамгийн их буюу 22 арга хэмжээг төлөвлөж 95.45 хувиар Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд “Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ” зорилтод тусгагдсан ажлууд тодорхой үр дүнд хүрсэн буюу 83.3 хувиар тус тус үнэлэгдсэн. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	0-30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна	1	-	1	-	-	-	90
2	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	7	5	1	1	-	-	94.2
3	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	22	18	3	-	-	1	95.45
4	Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ	3	2	-	-	1	-	83.3
Нийт		33	25	5	1	1	1	93.94

Чиглэл тус бүрээр авч үзвэл Виз зөвшөөрлийн газар, Зөрчил шалган шийдвэрлэх газар, Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсүүдийн хэрэгжүүлсэн арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 100 хувиар үнэлэгдсэн. Харин үнэлгээ буурсан арга хэмжээнд:

- Захиргаа, удирдлагын газар: хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан-2, бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа-1, нийт 3 арга хэмжээ;
- Иргэний харьяаллын газар: Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан гол үр дүн гарч эхэлж байгаа-1, нийт 1 арга хэмжээ;
- Мэдээллийн технологийн хэлтэс: Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан гол үр дүн гарч эхэлж байгаа-1, бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн-1, нийт 2 арга хэмжээ;
- Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс: тодорхой үр дүн гарч эхэлж байгаа ч хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай-1, нийт 1 арга хэмжээ байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	30%	0%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Захиргаа, удирдлагын газар	13	9	3	-	-	1	-	93.07
2	Виз, зөвшөөрлийн газар	2	2	-	-	-	-	-	100
3	Иргэний харьяаллын газар	1	-	1	-	-	-	-	90
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	3	-	-	-	-	-	100
5	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	2	2	-	-	-	-	-	100
6	Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	3	3	-	-	-	-	-	100
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс	2	2	-	-	-	-	-	100
8	Мэдээллийн технологийн хэлтэс	4	2	1	-	1	-	-	85
9	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс	1	-	-	1	-	-	-	70
10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	-	100
11	Санхүү хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	-	100
Нийт		33	25	5	1	1	1	-	93.94

Мөн газар, хэлтсүүдийн буюу Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1, Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1, нийт 2 арга хэмжээ 100 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2024 оны 09 дүгээр сард төлөвлөн гүйцэтгэсэн 33 арга хэмжээний хэрэгжилт 93.94 хувьтай үнэлэгдлээ. Цаашид дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай. Үүнд:

1. “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-50 хувьтай үнэлэгдсэн 2 арга хэмжээ Арга хэмжээ (14): “Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлуулах. (Хэрэгжилт 30 хувь).

- Захиргаа, удирдлагын газар удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэж батлуулах;

Арга хэмжээ (33): Eform.mn системд баримт бичгийн MRZ (machine readable zone) таних нэмэлт хөгжүүлэлт хийх. (Хэрэгжилт 50 хувь).

- Мэдээллийн технологийн хэлтэс тус арга хэмжээг сайжруулж, хөгжүүлэлтийн бүрэн хийж үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

2. “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-90 хувьтай үнэлэгдсэн 6 арга хэмжээ

Арга хэмжээ (4): Гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр иргэдийг зөвлөгөө, мэдээллээр хангах (Хэрэгжилт 70 хувь).

- Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс алдсан дуудлагын тоог багасгах чиглэлээр тодорхой ажил төлөвлөж, арга хэмжээ авч үйл ажиллагааг сайжруулах;

Арга хэмжээ (1) “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийг сайжруулах (Хэрэгжилт 90 хувь)

- Мэдээллийн технологийн хэлтэс тус арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлж, системийн үйл ажиллагааг жигдрүүлэх;

Арга хэмжээ (5): Монгол Улсын иргэний харьяаллын талаарх хүсэлтийг хүлээн авч, холбогдох ажиллагааг зохион байгуулах (Хэрэгжилт 90 хувь)

Иргэний харьяаллын газар зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан боловч үр дүнг нэмэгдүүлэх;

Арга хэмжээ (12): Байгууллагын үйл ажиллагаанд холбогдох тушаалын төслийн эрх зүйн үндэслэлийг хянах (Хэрэгжилт 90 хувь)

- Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаал, шийдвэрийн 2024 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийхэд байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээрх захирамжлалын баримт бичигт хууль зүйн үндэслэл нь шалтгаан, зориулалт, зорилготойгоо нийцээгүй буюу үндэслэл буруу 9 тушаал байсан. Иймд байгууллагын үйл ажиллагаанд холбогдох тушаалын төслийн эрх зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлэн сайжруулах;

Арга хэмжээ (17): Гадаад сургалтад албан хаагчийг хамруулах (Хэрэгжилт 90 хувь)

- Захиргаа, удирдлагын газар өөрсдөөс шалтгаалах арга хэмжээг бүрэн авч ажилласан ч хүрэх түвшинд бүрэн хүрээгүй;

Арга хэмжээ (21): Иргэн, аж ахуй нэгж, байгууллага, албан хаагчаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх (Хэрэгжилт 90 хувь)

- Захиргаа, удирдлагын газар зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан боловч үр дүнг сайжруулж, шуурхай шийдвэрлүүлэх;

3. “Үр дүнтэй” буюу 100 хувьтай үнэлэгдсэн 25 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.